



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ҮР ДҮНГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.



АУДИТЫН НЭР: ОЙЖУУЛАЛТАНД ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН, 2016 ОНЫ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙХ ДАВТАН АУДИТ

ЦЭЦЭРЛЭГ
2018

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн	
Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	жагсаалт.....	2
Тэргүүлэх аудитор Д. Уламбаяр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3-5
Аудитын менежер Т.Байгалмаа	Бүлэг 1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг аваагүй байна.	6-15
Ахлах аудитор Д. Нэргүйбаатар	Бүлэг 2. Аудитын дүнд үндэслэн аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээгүй, зарим хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцоогүй байна.	15-18
Аудитор Г.Цог-Эрдэнэ	Дүгнэлт	19
2018 оны 10 дугаар сар	Зөвлөмж	20
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагын санал	21-22
www.audit.mn	Тайлан баталгаажуулсан тушаал	23-24
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</i>	Албан шаардлага	25-29
ХАЯГ: <i>Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот</i>		

Товчилсон үгийн жагсаалт

АРА	АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
МУЕА	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
ДА	ДАВТАН АУДИТ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ИТХТ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД
БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
БОАЖЯ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БСУТА	БАЙГАЛИЙН СЭРГЭН УРГАЛТАНД ТУСЛАХ АЖИЛ
СДОА	СУМ ДУНДЫН ОЙН АНГИ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Ойжуулалтанд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 онд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хийх давтан аудит

Аудитын код: АРА-/2018/03-ГА-ДА

Аудитын хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Ойжуулалтанд зарцуулсан төсвийн хөрөнгийн үр дүнд хийсэн аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ойжуулалтын үр дүнг нэмэгдүүлэх зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд аудит хийж үнэлэх, дүнг аймгийн ИТХ, Засаг дарга, ҮАГ-т танилцуулах, цаашид зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх боломжит арга хэмжээг авч бодит үр дүнд хүрэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх
- Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй эсэх

Хамарсан хүрээ:

Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга, аймгийн БОАЖГазарт хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн болон 2017-2018 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ойжуулалтын үр дүнд холбогдох байгууллагыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх, албан шаардлагын хэрэгжилт, ойжуулалтын бодит гүйцэтгэлийг газар дээр үзэж тулган шалгах зэргээр Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Ойн тухай хууль

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- БОНХСайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 дүгээр хамтарсан тушаал: “Ойжуулалт, ойн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”
- Аудитын газрын 2016 оны 01/90 ААГ-/2016/02-ГА тоот албан шаардлага
- Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов 2016 оны А/24 тушаалаар баталгаажуулсан “Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангаар аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын даргад хүргүүлсэн зөвлөмжүүд
- Холбогдох бусад хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж зэрэг холбогдох бусад эрхзүйн актууд

Оршил

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зориулж төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын үр дүн”-г шалгасан. Энэ аудитын дүнгээс 154.4 сая төгрөгийн зөрчлийг арилгаж хамгаалалтын хашаа бариулж, 2 ба 3 дахь жилийн нөхөн тарилтыг гүйцэтгэгчээр хийлгүүлж хүлээн авах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т, ойжуулалтын үр дүнг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн 7 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга, БОАЖГ-т тус тус хүргүүлсэн байна.

Түүнчлэн 2014-2016 онд төсвийн хөрөнгөөр хийсэн ойжуулалт нь ургаагүй 4 гүйцэтгэгчтэй холбоотой 98.6 сая төгрөгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг аймгийн Цагдаагийн газраар шалгуулахаар шилжүүлсэн байна.

Албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн тухай албан бичиг, нотлох баримтуудыг аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн.

Харин аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаж ирүүлээгүй бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн тодорхой бус байсан.

Давтан аудитаар өмнөх аудитын дүнд үндэслэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, ойжуулалтын үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн БОАЖГ-ын ойн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн Засаг даргын дэргэдэх Сум дундын ойн ангийн Ойн инженерийг оролцуулан зарим газарт ойжуулалтыг гүйцэтгэсэн байгууллагын төлөөллийг байлцуулан газар дээр нь бодит байдлыг тулган шалгаж, бичгээр болон фото зургаар баримтжуулсан болно. Албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад 7 сумын нэр бүхий 8 газарт 2014-2016 онд хийгдсэн 165 га ойжуулалт, 50 га БСУТА-г хамруулсан ба 2017, 2018 оны ойжуулалтын тухайд 3 сумын нутагт хийгдсэн 45 га талбайн ойжуулалтыг хамруулсан болно. Түүнчлэн Цагдаагийн газарт шилжүүлэн шалгуулсан асуудлаас Тариат сумын Шанаатын булаг, Шанаатын мандалд хийсэн 100 га ойжуулалтын бодит байдлыг газар дээр нь очиж үзэж танилцсан болно.

БҮЛЭГ 1.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг аваагүй байна.

1. 1.1. Аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

1.1.1. 1.1.A. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын газраас 2016 онд “Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зориулж төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн аудитын дүнд үндэслэн илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох арга хэмжээ авах дараах 3 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг аймгийн БОАЖГ-ын даргад хүргүүлсэн юм. Үүнд:

1. Аудитад хамрагдсан ойжуулалтын ажлаас 7 сумын нэр бүхий 8 газрын 165 га талбайд улс, орон нутгийн төсвийн нийт 122.3 сая төгрөгийн хөрөнгөөр хийсэн ойжуулалт, 9.95 сая төгрөгөөр 50 га-д хийсэн БСУТА-ын гүйцэтгэл хангалтгүй, суулгачын амьдралт муу, 2 ба 3 дахь жилийн нөхөн тарилт, арчилгааг огт хийгээгүй, хамгаалах хашаа бариагүй, хаяг, тэмдэгжүүлэлт, анхааруулах самбар байршуулаагүй зэргээр БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны А-96/71 хамтарсан тушаалаар баталсан **“Ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”**-ын 4.7¹ дахь заалтыг зөрчсөн, БОАЖГ-ын даргын гүйцэтгэгч нартай байгуулсан “Ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ”²-г хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн. Иймд дээрх зөрчлийг арилгуулж гүйцэтгэгч нараар нөхөн тарилтыг хийлгүүлэх, хашаа, хаяг, анхааруулах самбарыг байршуулж хүлээн авах

2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд гүйцэтгэсэн ойжуулалт, ой нөхөн сэргээх, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгох, гүйцэтгэлийг хүлээн авахдаа **“Ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”**-ын 4.5 ба 4.6 –д заасан зарчмыг чанд баримтлан, мөн журмын 4.9-д заасны дагуу хүлээн авч нотлох баримтыг аудитын газарт ирүүлэх

3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг зориулалт бусаар зарцуулж зөвхөн сумын төвийн ногоон байгууламжийн хашаа, хамгаалалтанд 44.4 сая төгрөг зарцуулсан зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх, уг хашаанд мод тарьж цэцэрлэгжүүлэлт хийлгүүлэн хүлээн авах

Дээрх албан шаардлагын дагуу зөрчлийг арилгах нөхөн тарилтыг хийж хүлээлгэн өгөх, цэцэрлэгжүүлэлт хийлгэх тухай албан бичгийг аймгийн БОАЖГ-аас холбогдох

¹ “Ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилт хийх”

² 2014-2016 онд гүйцэтгэгч тус бүртэй байгуулсан гэрээ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэгч байгууллагууд дутуу ажлыг гүйцээх, нөхөн тарилт хийж хүлээлгэн өгөх баталгаа гаргаж ирүүлсэн тухай албан шаардлагын хариуг БОАЖГ-ын 2016.12.20-ны 263 тоот албан бичгээр ирүүлсэн. Түүнчлэн БОАЖГ-ын 2018 оны 09 сарын 03-ний өдрийн 175 тоот албан бичгээр албан шаардлагын хэрэгжилтийг дахин дэлгэрэнгүй байдлаар гаргаж ирүүлсэн байна.

Аймгийн БОАЖГ-аас гаргаж ирүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийн бодит байдлыг Тэргүүлэх аудиторын баталсан удирдамжийн дагуу БОАЖГ-ын мэргэжилтэн Г.Баасансүрэн, СДОА-н ойн инженер Б.Цасчихэр нарыг шалгалтын багт оруулан газар дээр нь очиж зарим газарт ойжуулалтын ажлын гүйцэтгэгч нарыг байлцуулан тулган шалгаж бичгээр болон фото зургаар баримтжуулсан бөгөөд хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

№	Ойжуулалт, БСУТА, ойн зурвас хийсэн газрын						
	Нэр	хэмжээ /га/	Санхүүжилтийн гүйцэтгэл мян.төг	Гүйцэтгэгчийн нэр	Ойжуулалтыг хүлээн авсан огноо,	Талбайд тарих тарьцын хэмжээ*	Жишиг талбайгаар тооцоход бодит байдалд байгаа нь
	2014-2016 он						
1	Батцэнгэл Овгор улаан	20	13250	Ойд хангай ХХК	2016.10.20	50000	0
2	Эрдэнэмандал сумын Тээл багийн Өл БСУТА	50	9950.0	Мөнхгэрэлмандал ХХК	2016.10.20		0
3	Өлзийт байширын Шандат	25	16529.7	Ойд хангай ХХк	2015.10.20	62500	0
4	Хотонт Модот толгой	20	13300	Ойд хангай ХХк	2016.10.20	50000	20000
5	Цэцэрлэг Эхний хавтгай	40	27787	Ойд хангай ХХк	2015.10.20	100000	40000
6	Хайрхан Адуун зураа	20	13800	Олз мод ХХК	2015.10.20	50000	17500
7	Хайрхан Хэцүүгийн овоо	20	13800	Олз мод ХХК	2015.10.20	50000	0
8	Өндөр-Улаан Бэлхийн Гарчин	20	12800	Ойд хангай ХХК	2016.10.20	50000	0
		215	121216.7			412500	77500

*ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээнд 1 га-д тарих таримал модны доод хэмжээг 2500 ширхэг байна гэж тусгасан.

Дээрх хүснэгтээс харвал ойжуулсан талбайд ургасан байх ёстой таримал модны ойролцоогоор 18.8 хувь нь ургаж байгаа буюу ойжуулалтын үр дүн 18.8 хувь гэж үзэж болохоор байна. /Фото зургийг тайлангийн хавсралтаас үзнэ үү./

Албан шаардлагын дагуу зөрчлийг арилгасан талаарх ирүүлсэн хариуг газар дээр нь үзэж шалгасан бодит байдалтай харьцуулан дэлгэрэнгүй танилцуулбал:

1. Батцэнгэл сумын Баян-Уул багийн Овгор улаан 15 га ойжуулалт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 13.3 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК 2016 онд ойжуулалтын ажлыг гүйцэтгэж, хүлээж авах ажлын хэсгийн /цаашид ажлын хэсэг гэх/ 2016.10.20-ны №02 дугаар актаар тарьцын амьдралт 79% гэж хүлээн авсан боловч аудитын явцад 40 орчим хувийн ургалттай, хамгаалалт хаяг тэмдэгжүүлэлт хийгээгүй байсанд албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу “Ойд хангай” ХХК нь **“2 настай шинэсний 15000 гаруй суулгацаар нөхөн тарилт хийж унанги модыг ашиглан хамгаалалтын ажил хийж, анхааруулах самбар байршуулсан”** гэж хариуг ирүүлсэн.

Бодит байдал:

2018.09.13-ний өдөр шалгалтын багийн гишүүд Батцэнгэл сумын байгаль хамгаалагч Ш.Гэндэнсүрэнг байлцуулан газар дээр нь үзэж **шалгахад нөхөн тарилт хийгээгүй, ургаж байгаа тарьц суулгацын тоо хангалтгүй, байгалийн сэргэн ургалттай газарт ойжуулалт хийсэн, хашаа хамгаалалтгүй** байлаа.

2. Өлзийт сумын Байшир багийн Шандат 25 га ойжуулалт:

Орон нутгийн төсвийн 16.5 сая төгрөгөөр 2015 онд “Ойд хангай” ХХК ойжуулалтын ажил гүйцэтгэж, ажлын хэсгийн 2015.10.20-ны өдрийн актаар тарьцын амьдралт 81% гэж хүлээн авсан гэх боловч аудитын явцад 40 орчим хувийн ургалттай байсанд албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу **2 настай шинэсний 32110 ширхэг суулгацаар нөхөн тарилтыг 2018 оны хавар хийж гүйцэтгэсэн** гэсэн хариуг ирүүлсэн.

Бодит байдал:



Өлзийт сумын Байшир баг Шандат ойжуулсан талбай
2018.09.13

2018.09.13-ний өдөр шалгалтын багийн гишүүд Өлзийт сумын байгаль хамгаалагч Н.Самданг байлцуулан газар дээр нь үзэж 3 хэсэг газарт 20х20 хэмжээний жишиг талбай авч шалгахад **нөхөн тарилт хийснийг нотлох болон зориудаар тарьц суулгасан ямар нэг ул мөргүй, ургаж байгаа тарьц байхгүй, хашаа хамгаалалтгүй, анхааруулах самбаргүй** байлаа.

3. Хотонт сумын Өндөрт сант багийн Модот толгой 25 га ойжуулалт:

Улсын төсвийн 13.3 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК 2016 онд 25 га-д ойжуулалтын ажил гүйцэтгэснийг ажлын хэсэг 2016.10.20-ны өдрийн актаар тарьцын амьдралт 75% хүлээн

авсан боловч аудитаар 10 га-д хийсэн ойжуулалтын тарьцын 10% нь ургасан байсанд албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу **2 настай шинэсний 18350 ширхэг суулгацаар нөхөн тарилтыг 2017 оны намар хийж гүйцэтгэсэн** гэсэн хариу ирүүлсэн.

Бодит байдал:

Шалгалтын багийн гишүүд Хотонт сумын байгаль хамгаалагч Н.Ширзагд, “Ойд хангай” ХХК-ний захирал Г.Цэгмид нарыг байлцуулан газар дээр нь үзэж 3 хэсэг газарт 20х20 хэмжээний жишиг талбай авч шалгахад нийт **192 тарьц суулгац тоологдсны 96 буюу 50 хувь нь амьд тарьц байв. Мөн хашаа хамгаалалтыг тор төмрөөр хийсэн боловч нутгийн иргэд торыг тасдаж ойжуулсан талбайд орсон байна. Анхааруулах самбар хангалтгүй** байлаа.

4. Цэцэрлэг сумын Их булаг багийн Эхний хавтгай 40 га ойжуулалт:

Улсын төсвийн 27.8 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК 2015 онд ойжуулалтын ажил гүйцэтгэснийг ажлын хэсгийн 2015.10.20-ний өдрийн актаар тарьц амьдралт 76.6 хувьтай хүлээж авсан боловч аудитын явцад тарьцын 52.3 хувь нь ургасан, хамгаалалт хаяг тэмдэгжүүлэлт, анхааруулга самбар хийгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын дагуу **2 настай шинэсний 35000 ширхэг суулгацаар нөхөн тарилтыг 2017 оны намар хийж гүйцэтгэсэн** гэсэн хариуг ирүүлсэн.

Бодит байдал:

Шалгалтын багийн гишүүд 2018.09.19-ний өдөр Цэцэрлэг сумын байгаль хамгаалагч Г.Энхбатыг байлцуулан уг талбайд газар дээр нь үзэж шалган 2 хэсэг газарт 20х20 жишиг талбай авч амьд тарьцыг тоолж үзэхэд **40 хувь амьдралттай, хамгаалах хашаа барьсан боловч нурж унасан, анхааруулах самбар байршуулаагүй** байлаа.



Цэцэрлэг сумын Ихбулаг багийн Эхний хавтгай 2018.09.19 Тарьцын ургасан, Хашаа нурсан байдал

5. Эрдэнэмандал сумын Тээл багийн Өл 50 га БСУТА:

Орон нутгийн төсвийн 9.95 сая төгрөгөөр “Мөнхгэрэлмандал” ХХК БСУТА-ыг 2016 онд гүйцэтгэсэн. Өмнөх аудитаар үрийн цухуйлт 40%, хамгаалах хашаа бариагүй,

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

анхааруулах самбар байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Энэ албан шаардлагын дагуу **16000 орчим үрийн модтой 40х40 см хэмжээтэй 15000 орчим үр унах талбай бэлтгэж, унанги мод ашиглан хамгаалалтын ажил, анхааруулах самбар байршуулсан** гэж хариу ирүүлсэн.

Бодит байдал:

Шалгалтын багийн гишүүд газар дээр нь үзэж танилцахад **хамгаалах хашаа, анхааруулах самбаргүй, 2 хэсэг газарт жишиг талбай авч үзэхэд үр цухуйлт хангалтгүй** байв.

6. Хайрхан сумын Хэцүүгийн овоо 20 га ойжуулалт:

Улсын төсвийн 13.8 сая төгрөгөөр “Олз мод” ХХК 2015 онд гүйцэтгэснийг тарьцын амьдралт 75% гэж ажлын хэсгийн 2015.10.20-ний өдрийн актаар хүлээн авсан. Өмнөх аудитаар тарьцын амьдралтыг тодорхойлох боломжгүй, нөхөн тарилт хийгээгүй, хамгаалах хашаа, анхааруулах самбар байршуулаагүй зөрчил илэрснийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн. Энэ дагуу **2 настай шинэсний 20000 гаруй суулгацаар 2017 оны намар нөхөн тарилт хийж, амьдралтын хувь 73 болж нэмэгдсэн** гэж хариу ирүүлсэн.

Бодит байдал:



2018.09.20-ний өдөр шалгалтын багийн гишүүд “Олз мод” ХХК-ний захирал Л.Олзвойбаатарыг байлцуулан газар дээр нь үзэж шалгахад **талбайд тарьц суулгац байхгүйгээс тооллого хийх боломжгүй байлаа. Мөн хамгаалалтын хашаа бариагүй** байв.

Хайрхан сумын Хэцүүгийн овоо 2018.09.20 талбайг цэвэрлээгүй, хамгаалах хашаа бариагүй байгаа нь

7. Хайрхан сумын Жарантай багийн Адуун зураа 20 га ойжуулалт:

Улсын төсвийн 13.8 сая төгрөгөөр “Олз мод” ХХК 2015 онд гүйцэтгэснийг тарьцын амьдралт 75% гэж ажлын хэсгийн 2015.10.20-ний өдрийн актаар хүлээн авсан. Өмнөх аудитаар ойжуулсан талбайд тарьц суулгац байхгүйгээс амьдралтыг тодорхойлох боломжгүй, нөхөн тарилт хийгээгүй, хамгаалах хашаа, анхааруулах самбар байршуулаагүй зөрчил илэрснийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн. Энэ дагуу **2 настай шинэсний 20000 гаруй суулгацаар 2017 оны намар нөхөн тарилт хийж, амьдралтын хувь 73 болж нэмэгдсэн** гэж хариу ирүүлсэн.

Бодит байдал:

2018.09.21-ний өдөр “Олз мод” ХХК-ний захирал Л.Олзвойбаатар, Хайрхан сумын байгаль хамгаалагч Д.Энэбиш нарыг байлцуулан газар дээр нь үзэж шалгахад

хамгаалалтын хашаа бариагүй байв. Ойжуулсан талбай нь байгалийн сэргэн ургалттай газар бөгөөд 2 хэсэг газарт 20х20 харьцаатай 2 жишиг талбай авч тарьцыг тоолж шалгахад 40 тарьц тоологдсноос амьд тарьцын тоо 14 буюу амьдралт 35 хувь байлаа.

8. Өндөр-улаан сумын Бэлхи багийн Гарчин 20 га ойжуулалт:

2016 онд орон нутгийн төсвийн 12.8 сая төгрөгөөр 20 га-д ойжуулалтыг “Ойд хангай” ХХК гүйцэтгэсэн. Өмнөх аудитаар тарьцын амьдралт 50% байгааг нөхөн тарилт хийж амьдралтыг хувийг 75-аас доошгүй хувьд хүргэн хүлээлгэн өгөх албан шаардлага хүргүүлсэн. Энэ дагуу **нөхөн тарилтыг 2018 оны хавар 2 настай шинэсний 17000 орчим суулгацаар хийж, унанги модоор хамгаалах хашаа хийж, анхааруулах самбарыг байршуулсан** гэж хариуг ирүүлсэн.

Бодит байдал:

Шалгалтын багийн гишүүд газар дээр очиж 5мх5м харьцаатай жишиг талбайг 4 хэсэг газар сонгон авч хэмжилт хийн ургацыг үзэхэд **тарьц суулгац байхгүйгээс тоолох боломжгүй, хамгаалалтын хашаа бариагүй, анхааруулах самбар байршуулаагүй** байв.

ДҮГНЭЛТ:

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан тухай албан шаардлагын хэрэгжилтийг газар дээр нь шалгасан дээрх шалгалтын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аудитаар нийт 7 сумын нэр бүхий 8 газарт 2014-2016 онд **165 га** талбайд ойжуулалт хийсэнийг тооллого хийж шалгахад Хотонт сумын Модот толгой 20 га, Цэцэрлэг эхний хавтгай 40 га, Хайрхан сумын Адуун зураа 20 га нийт 80 га-д хийсэн ойжуулалт 35-40 хувь амьдралттайгаас бусад ойжуулалт хийсэн 85 га талбайд таримал мод ургаагүй, хамгаалах хашаа бариагүй, анхааруулах самбар байршуулаагүй байсан нь өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй гэж үзэхэд хүргэж байна. Энэ 165 га талбайд ойжуулалтын үр дүнд хамгийн багадаа /2500ширхэг*165га*75%/ **412500** ширхэг таримал мод ургасан байх ёстой. Гэтэл аудитын шалгалтаар бодит байдалд ойролцоогоор **77500** ширхэг таримал мод байгаа нь байх ёстой модны 18.8 хувь буюу **маш хангалтгүй** байлаа.

Эндээс үзвэл аймгийн БОАЖГ нь Төрийн аудитын газраас хүргүүлсэн албан шаардлагын утга агуулгад ач холбогдол өгөөгүй, өмнөх албан шаардлагад дурдсан бүх ойжуулалт хийсэн газарт албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавиагүй, эцсийн дүндээ улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн **81.2** хувийн зарцуулалт үр дүнгүй болсон байна.

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал “эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж” шийдвэрлэгдсэн байна.

“Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д 2016 онд хийсэн аудитаар хууль, тогтоомж гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй нэр бүхий 4 аж ахуйн нэгжийн 121 га талбайд хийсэн ойжуулалт ургаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж төсвийг хохироосон байж болзошгүй дараах асуудлыг аймгийн Цагдаагийн газарт 2016 оны 10 сарын 11-ний өдөр 310 тоот албан бичгээр шилжүүлсэн болно. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

№	Ойжуулалт, БСУТА, ойн зурвас хийсэн газрын				Ойжуулалтыг хүлээн авсан огноо,	Улсын комисс хүлээн авах үеийн амьдралтын хувь*	Аудитын шалгалтаар таримал модны тоо, хувь
	Нэр	хэмжээ /га/	Санхүүжилтийн гүйцэтгэл мян.төг	Гүйцэтгэгчийн нэр			
1	Цэнхэр сумын Янгиртай хясаанаас Хэвтээ толгой хүртэлх ойн зурвас	11	22000.0	“Элэгтэй хайрхан” ХХК	2014.10.22	76.9	0
2	Булган сумын Булган уулын зүүн суга	10	6900.0	“Дуут” нөхөрлөл	2014.10.20	76.0	0
3	Тариат сумын Шанаатын мандал	50	34600.0	“Олз мод” ХХК	2016.10.20	75	0
4	Тариат сумын шанаатын булаг	50	34700.0	“Ойд хангай” ХХК		75	0
		121	98200.0			412500	0

Дээрх зөрчил ба асуудлыг шийдвэрлэсэн байдлыг танилцуулбал:

- Орон нутгийн төсвийн 22.0 сая төгрөгөөр “Элэгтэй Хайрхан” ХХК-ний 2014 онд Цэнхэр сумын Янгиртай хясаанаас Хэвтээ толгой хүртэлх 11 га-д ойн зурвас байгуулах ажлыг ойжуулалт хүлээн авах ажлын хэсгийн 2014 оны актаар 1 га-д 500 ширхэг нийт 5500 ширхэг тарьц ургасан гэж хүлээн авсан байсан боловч 2016 оны аудитын шалгалтаар тэнд 0.1 га-д хайс барьснаас өөр ямар ч ажил хийгдээгүй байлаа. Иймд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж хувьдаа ашигласан байж болзошгүй асуудлыг шалгуулахаар шилжүүлснийг аймгийн Цагдаагийн газар хэрэг бүртгэлийн дугаар нээж шалгасан байна. Улмаар аймгийн Прокурорын газраас материалыг хянаж “... Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байх боловч тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан цаашид байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон үндэслэлээр хяналтын прокурорын 2016.12.21-ний 541 дугаартай тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.”³

³ Архангай аймгийн Прокурорын газрын 2018.09.06-ний 2/970 албан тоот бичиг

2. Орон нутгийн төсвийн 6.9 сая төгрөгөөр “Дуут” нөхөрлөлийн Булган уулын зүүн суганд 10 га-д хийсэн ойжуулалтын ажлыг аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2014.10.20-ний актаар тарьцын амьдралтын хувь 76, нэг га-д 1900, нийт талбайд 19000 ширхэг таримал мод ургасныг тогтоож хүлээн авсан байв. Гэтэл 2016 оны аудитын уг талбайд таримал мод огт ургаагүй байсан тул төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж хувьдаа ашигласан байж болзошгүй асуудлыг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн. Цагдаагийн газраас “...Дуут нөхөрлөлийн ахлагч нь улсын комиссын гишүүдтэй үгсэн хуйвалдаж хуурамч акт үйлдсэн гэх бүртгэлийн ... дугаартай материалыг хянаад гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хэлбэрийн төдий агуулсан, гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хяналтын прокурорын 2016.12.21-ний 540 дугаартай тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ.”⁴
3. Улсын төсвийн хөрөнгөөр “Олз мод” ХХК-ний Тариат сумын Шанаатын мандал 50 га-д 34.6 сая төгрөгөөр хийсэн ойжуулалт, “Ойд хангай” ХХК-ний Тариат сумын Шанаатын булагт 50 га-д 34.7 сая төгрөгөөр хийсэн ойжуулалтыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ойжуулалтыг хүлээн авах комиссын 2014.10.20-ний актаар тарьцын амьдралтын хувь 75, нэг га-д 1875 ширхэг, нийт 93750 ширхэг таримал мод ургасан гэж тус тус хүлээн авсан боловч 2016 оны аудитаар дээрх 2 талбайд таримал мод тоологдоогүй. Иймд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж хувьдаа ашигласан байж болзошгүй асуудлыг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт шилжүүлснийг Цагдаагийн газар “эрүүгийн албаны чиглэлээр шалгахад ойжуулалтын ажлын хугацаа дуусаагүй, нөхөн тарилтын ажил хийгдээгүй байсан тул хэргийг хааж шийдвэрлэсэн байна.”⁵

1.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2.А. Аймгийн Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийн 33 хувь хэрэгжээгүй байна.

Өмнөх аудитын дүнгээс ойн санг нөхөн сэргээх, ойжуулах талаар орон нутгийн бодлого, төлөвлөгөөг тодорхой болгох, ойжуулалтыг чанартай гүйцэтгүүлэх, ойжуулалтанд төсвөөс зарцуулах хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, ойжуулалтын үр ашгийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн 7 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Тухайлбал: аймгийн Засаг даргад 3, аймгийн БОАЖГ-ын даргад 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд 2016 оны жилийн эцэст нийт зөвлөмжийн 57 хувийг биелүүлсэн мэдээлэлтэй байлаа.

Давтан аудитын явцад өмнөх аудитаас аймгийн Засаг даргад хүргүүлсэн дараах зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Үүнд:

- “Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалтыг хэрэгжүүлж ой бүхий сумын “Ойн менежмент төлөвлөгөө”-г батлах, хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж дүнг аймгийн ИТХ-д хүргүүлэх” зөвлөмжийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд аймгийн хэмжээний ойн санд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Энэ ажлын тайлан эцэслэн гараагүй байгаагаас түүнд үндэслэн

⁴ Мөн тэнд

⁵ Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 2018.10.03-ний 31/2383 тоот албан бичиг

боловсруулах аймаг, сумын ойн менежмент төлөвлөгөөг батлуулах ажил хүлээгдэж байгаагаас зөвлөмж хэрэгжээгүй байна.

Өмнөх аудитын дүнгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү.

1.2.Б. Аймгийн БОАЖГ-ын даргад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнд:

- Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, ой бүхий сумын ойн менежмент төлөвлөгөөг хянаж, аймгийн засаг даргаар батлуулах, аймгийн “ойн менежементийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж нэн даруй батлуулах... зөвлөмжийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд аймгийн хэмжээний ойн санд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна. Энэ ажлын тайлан эцэслэн гараагүй байгаагаас түүнд үндэслэн боловсруулах аймаг, сумын ойн менежмент төлөвлөгөөг батлуулах ажил хүлээгдэж байгаагаас зөвлөмж хэрэгжээгүй байна.
- Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах явцад 2014-2016 оны ойжуулалтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, 2 ба 3 дахь жилийн нөхөн тарилтыг хийж БОАЖГ-т хүлээлгэн өгөөгүй, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэнд аудитаас “Ойжуулалтын ажлын гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, урьд оны ойжуулалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудтай улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахгүй байх” гэсэн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлэлгүй “Ойд хангай” ХХК, “Олз мод” ХХК-иудтай 2017, 2018 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт хийлгэх гэрээг дахин байгуулсан байна.
- “Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудаар тухайн жилийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэвэл зохих ойжуулалтыг заавал хийлгэж, хүлээн авах, ойжуулалт хүлээн авсан гүйцэтгэлийн актыг олон нийтэд нээлттэй мэдээлэх” зөвлөмжийн хүрээнд 2017, 2018 онд ойн мэргэжлийн байгууллагууд нийт 52 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн мэдээлэлтэй боловч албан ёсоор хүлээн авсан баримтгүй байгаа нь зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй гэж үзэхэд хүргэж байна.

Дүгнэлт

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, албан шаардлагыг биелүүлээгүй, зөвлөмжийн 42.8 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Өмнөх аудитаас өгөгдсөн, бүрэн хэрэгжүүлээгүй 3 зөвлөмжийг хэрэгжүүлж үр дүнг тооцох ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй аймгийн БОАЖГ-ын даргад Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасан сахилгын шийтгэл оногдуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэх,
3. Бодит байдал дээр ойжуулалт огт хийгдээгүй, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй асуудлыг шүүхийн байгууллагад шилжүүлж, гэрээний хэрэгжилтийг хангуулан төсвийг хохиролгүй болгох талаар тодорхой арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлэх.

БҮЛЭГ 2

Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн байдал

2.1. Аудитын дүнд үндэслэн аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээгүй байна.

2.1.А. Аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй.

Аймгийн БОАЖГ-ын 2017, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх талаар ямар нэг ажил, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй байна.

2.1.Б. Ойжуулалтын үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмжийг биелүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг дарга, БОАЖГ-ын даргад өмнөх аудитын дүнд үндэслэн ойн санг нөхөн сэргээх, ойжуулах талаар орон нутгийн бодлого төлөвлөгөөг тодорхой болгох, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулснаар аймгийн хэмжээний ойн сан нэмэгдэх, байгалийн аясаар сэргэн ургах нөхцлийг бүрдүүлэх, ойгоос олох орлого, ажлын байр нэмэгдэх, ойжуулалтын ажлын чанар, ашгийг нэмэгдүүлэх, үр дүнг тооцож үнэлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зэрэг үр дүн бүхий зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

2.2. Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж үр дүнг тооцоогүй байна.

2.2.А. Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцож үнэлээгүй байна.

Аймгийн Засаг дарга болон аймгийн БОАЖГ-ын даргад хүргүүлсэн зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргад 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн бөгөөд дараах зөвлөмжүүдийг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлсэн байна.

- Орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2017 онд ойжуулалт, ойн аж ахуйн 8 арга хэмжээнд 203.5 сая төгрөг баталсан нь тухайн оны ойн нөөц ашигласан төлбөрийн орлогын /357.9 сая төгрөг/-ын 56.8 хувь, 2018 онд 201.2 сая төгрөгийг ойжуулалт, ойн аж ахуйн 8 арга хэмжээнд зарцуулахаар тооцож төлөвлөж батлуулсан нь тухайн оны ойн нөөц ашигласны орлого /340.0 сая төгрөг/-ын 59.1 хувьтай тус тус тэнцэж байгаа нь өмнөх онуудаас өссөн боловч “Орон нутгийн төсвөөс ойг хамгаалах нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг ойн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын 85 хувиар тооцон төлөвлөж батлуулах” зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь Ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.
- Ойд цэвэрлэгээ хийх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжих, урамшуулах талаар орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах талаар тодорхой арга хэмжээг авах зөвлөмжийн хариуд “2017 онд ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, экологид ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж дундын сангаа арвижуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ойн санг гэрээгээр эзэмшигч 16 нөхөрлөлд тус бүр нэг сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ ... хууль бус мод бэлтгэлт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах талаар мэдлэг мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор сэрэмжлүүлэг бүхий 17 ширхэг самбарыг эзэмшлийн ойн сангийн ойролцоо байрлууллаа ... байгалийн сэргэн ургалт явагдаж буй талбайг хүн малын хөлд гишгэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 3630 метр урт хамгаалалтын хашааг барьж хашаажуулсан, ... ойгоос унанги, гишүү, мөчир, навч, боргоцой ... ойн баялагаар экологид ээлтэй 50 гаруй бүтээгдэхүүнийг урласан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ... шинээр байгуулагдсан ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих, менежментийн төлөвлөгөөтэй болгож, ойн санг ... хамгаалах, зүй зохистой ашиглах үйл ажиллагааг тогворжуулах ажлын хүрээнд шинээр байгуулагдсан ... нөхөрлөлүүдийн ойн сангийн 15000 га талбайд ой зохион байгуулалтын ажлыг хийж ажлын тайланг хүлээлгэн өглөө...”⁶ гэсэн тайлбар ирүүлсэн байна.
- 2. Аймгийн БОАЖГ-ын даргад 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлснээс дараах зөвлөмжүүдийг тодоорхой хэмжээгээр хэрэгжүүлжээ.
- Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудаар тухайн жилийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэвэл зохих ойжуулалтыг заавал хийлгэж, хүлээн авах, ойжуулалт хүлээн авсан гүйцэтгэлийн актыг олон нийтэд нээлттэй мэдээлэх” зөвлөмжийн хүрээнд 2017, 2018 онд ойн мэргэжлийн байгууллагууд нийт 52 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн мэдээлэлтэй боломжтой албан ёсоор хүлээн авсан баримтгүй байгаа нь зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй гэж үзэхэд хүргэж байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр түүнчлэн ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн, хийж буй талбайд технологийн болон үе

⁶ Аймгийн ЗДТГ-ын даргын 2018.09.03-ний 03/912 албан бичгийн хавсралт

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

шатны хяналтыг жилд 2-оос доошгүй удаа хийж баримтжуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийн хүрээнд сум дундын ойн анги, сумдын ЗДТГ-тай хамтран жил бүрийн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийн явцтай 3 удаа танилцаж инженер, техникийн ажилтнуудад заавар зөвлөмж өгч хамтран ажилласан”⁷ боловч орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд ойжуулалт хийгдсэн талбайд тарьц суулгац ургаагүй, суулгацын тоо хангалтгүй байгаа зэрэг нь үр дүн багатай болсныг илтгэж байна.

2.2.Б. орон нутгийн төсвөөс 2017, 2018 онд ойжуулалтанд олгосон хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан ба ойжуулалт үр дүнгүй болсон байна.

2017 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтээр орон нутагт хийх ойжуулалтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, санхүүжүүлэх, ойжуулалтыг хүлээн авах зэрэг үйл ажиллагааг БОАЖЯ-ны “Ойн судалгаа хөгжлийн хүрээлэн” хариуцдаг болсон байна. Иймээс улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ойжуулалтын материал орон нутагт байхгүй.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017, 2018 онд ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн газрын байршил ба бодит байдлыг байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3.

№	Ойжуулалт хийсэн газрын нэр	Хэмжээ /га/	Гэрээний дүн /мян.төг/	Санхүүжилт /мян.төг/	Гүйцэтгэсэн он	Гүйцэтгэгч байгууллагын нэр		Тарьцын ургалт аудитын шалгалтаар
1	Булган сумын Баянбулаг баг Баянбулаг	20	12000.0	12000.0	2017	Олз мод ХХК		Очиж шалгаагүй.
2	Эрдэнэбулган сумын Булган уулын баруун суга	20	13000.0	13000.0	2017	Олз мод ХХК		Огт ургаагүй.
3	Чулуут сумын Жавлантын дэнж	12.5	8459.3	4229.6	2018	Ойд ХХК	хангай	62.5 %
4	Батцэнгэл сумын Баян Уул багийн Овоот	12.5	8659.3	4329.7	2018	Ойд ХХК	хангай	40.2%
		65	42118.6	33559.3				

Дээрх ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг газар дээр очиж үзэж шалгахад дараах байдалтай байлаа.

1. Булган сумын Баянбулаг багийн Баянбулагийн аманд 20 га-д 2017 онд “Олз мод” ХХК-ний 13.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ойжуулалтын ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2017.11.03-ний өдрийн актаар нэг га-д 1875 ширхэг, нийт талбайд 37500 ширхэг таримал мод ургасан... тарималын жилийн

⁷ Аймгийн БОАЖГ-ын 2018.09.03-ний 175 тоот албан бичгийн хавсралт

өсөлт 2.3.-3.0 см ерөнхий байдал хэвийн...”⁸ гэж хүлээн авсан байв. Аудитын багийн гишүүд газар дээр очиж танилцаж чадаагүй.

2. Эрдэнэбулган сумын Булган уулын баруун суганд 20 га талбайд 2017 онд “Олз мод” ХХК-ний 13.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ойжуулалтын ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2017.11.03-ний өдрийн актаар нэг га-д 1875 ширхэг, нийт талбайд 37500 ширхэг таримал мод ургасан... тарималын жилийн өсөлт 2.3.-3.0 см ерөнхий байдал хэвийн...”⁹ гэж хүлээн авсан байв. Аудитын багийн гишүүд 2018.09.26-ний өдөр гүйцэтгэгч “Олз мод” ХХК-ний захирал Л.Олзвойбаатарыг байлцуулан шалгахад уг ойжуулсан гэх талбайд **таримал мод байхгүй, хамгаалалтын хашаа бариагүй** байлаа.
3. Батцэнгэл сумын Баян уул багийн овоотод 12.5 га-д “Ойд Хангай” ХХК-ний 2018 онд гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг 2018.09.12-ний өдөр БОАЖГ-ын мэргэжилтэн Г.Баасансүрэн, СДОА-ын ойн инженер Б.Цасчихэр нарын хамт “Ойд хангай” ХХК-ний захирал Г.Цэгмидийг байлцуулан газар дээр шалгалаа. Энэхүү ойжуулсан талбайд 2 хэсэг газарт 20х20 хэмжээтэй жишиг талбай авч тарьцыг тоолоход нийт 40 тарьц тоологдсоноос амьд тарьцын тоо 17 ширхэг буюу нийт тарьцын **амьдралт 40.2 хувьтай байв. хамгаалалтын хашаа барьсан боловч нурсан.**
4. Чулуут сумын Жавхлантын дэнж 12.5 га-д хийх ойжуулалтыг сумын Засаг даргын хүсэлтээр Зуун мод багийн Тооромтын үзүүр, Хэсэг мод хэмээх газарт шилжүүлэн хийсэн байна. Ойжуулалтын ажлыг газар дээр очиж 5мХ5м харьцаатай жишиг талбайг 4 хэсэг газар сонгон авч хэмжилт хийн ургацыг үзэхэд дундажаар 2-3 бут ургасан, тарьцын өндөр 7-12 см-ийн хэмжээтэй тарьцын ургалт дундажаар **62.5 хувийн гүйцэтгэлтэй** байлаа.

Дүгнэлт

2017, 2018 оны хийгдсэн ойжуулалтын үр дүн хангалтгүй, 2 дахь жилийн нөхөн тарилт, арчилгаа тордолгоог хийгээгүй, хамгаалах хашаа бариагүй зэргээр төсвийн хөрөнгийг мөн л үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

- 2017 оны ойжуулалтын нөхөн тарилтыг хийлгэж ажлын тарьцын амьдралт 75-аас дээш хувиар хүлээн авах, 2018 оны ойжуулалтыг хүлээн авахад тарьцын амьдралтын хувиас гадна хамгаалах хашаа, анхааруулах самбар байршуулах шаардлагыг тавих, ойжуулалтыг хүлээн авахад БОНХС, Сангийн Сайдын 2013 оны А-96/71 тушаалаар баталсан журмыг чанд мөрдөж хүлээн авах нотлох баримтыг ирүүлэх албан шаардлагыг БОАЖГ-т хүргүүлэв.

⁸ Аймгийн засаг даргын 2017 оны А/495 захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2017.11.03-ний өдрийн №02 тоот акт

⁹ Аймгийн засаг даргын 2017 оны А/495 захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2017.11.03-ний өдрийн №01 тоот акт

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Давтан аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч зөрчлийг бүрэн арилгаагүй байна.
2. Өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийн 42.8 хувийн хэрэгжилтийг хангаагүй байна.
3. Аудитын дүнд үндэслэн аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлээгүй байна.
4. Аудитын мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, зарим хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцоогүй байна.

Давтан аудитаар өмнөх аудитаас өгсөн боловч бүрэн хэрэгжүүлээгүй 3 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, 2017, 2018 онд хийгдсэн ойжуулалтын нөхөн тарилт, хамгаалах хашаа зэрэг гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж хүлээн авах, цаашид ойжуулалт бүрийн 2 дахь, 3 дахь жилийн нөхөн тарилт, хамгаалах хашаа хийлгэх ажлыг гүйцэтгүүлж гэрээний хэрэгжилтийг хангуулж байх, 2014-2016 онд төсвөөс санхүүжилт авч хэрэгжүүлэн хүлээлгэн өгсөн боловч уг талбайд таримал мод байхгүй буюу төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлагыг БОАЖГ-т хүргүүлэх, ойжуулалтанд зарцуулах хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, ойжуулалтын үр дүнг дээшлүүлэх зөвлөмжийг аудитын тайлангаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

-----oOo-----

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн БОАЖГ-ын дарга Н.Баянмөнхөд

1. Давтан аудитын дүнгээс өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилт, үр дүнг тооцож тайланг ирүүлэх
2. Ойжуулалтын ажлын гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, урьд оны ойжуулалтын ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудтай ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахгүй байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 12 дугаар 01-ний дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлэх

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2018.10.08

Холбогдох байгууллагын санал



АРХАНГАЙ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас: 7033-3223, Факс: 7033-3223
E-mail: arkhangai_env@mail.mn

2018. 10. 11 № 204

танай 2018. 10. 10-ны № 215 -т

Санал хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Амгасгал

1. Саналыг судалж үзэх.

2. Алба хэрэглэх!

3. Төрийн саналыг судалж, үзүүлэх! Дүн 16/2

Танай байгууллагын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу "Ойжуулалтад төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 оны зөвлөмжийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын зөрчлийн асуудалтай танилцлаа. Өмнөх онд ойжуулсан талбайн амьдралтын хувьд муу байгаа нь уур амьсгалын өөрчлөлт болон малын хэт их өсөлттэй холбоотой юм. 2014-2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг гүйцэтгүүлэх хугацаанд тус газрын даргын албыг өөр хүн хашиж байсан тул Аудитын багийн шийдвэр /БОАЖГ-ын даргад Төрийн Аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэх/-тэй санал нийлэхгүй байна.

2017 онд Булган уул, Баянбулагт ойжуулсан 40 га талбайн нөхөн тарилтын ажлыг гүйцэтгүүлэхийг уламжилъя.

Аймгийн хэмжээнд 2016-2018 онд хэрэгжүүлсэн ойн цэвэрлэгээний ажил, бэлтгэсэн мод болон ойжуулсан талбайн судалгааг хавсралтаар хүргүүлэв.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.БАЯНМӨНХ



А/а. Нэрлүүлэгч
а. Т. Цог-Орлом
1. Амгасгалыг судалж үзэх.
2. Саналыг судалж үзэх.
3. Төрийн саналыг судалж үзүүлэх!
Дүн 16/2

000133

**Холбогдох байгууллагын саналын дагуу
авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

“Ойжуулалтанд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 онд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт”-д хийсэн давтан аудитын тайланд аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн саналыг судалж үзээд дараах арга хэмжээг авлаа. Үүнд:

1. “Өмнөх онд ойжуулсан талбайн амьдралтын хувь муу байгаа нь уур амьсгалын өөрчлөлт болон малын хэт өсөлттэй холбоотой юм” гэсэн тайлбарыг ирүүлжээ. Гэтэл БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны А-96/71 хамтарсан тушаалаар баталсан **“Ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”**-ын 4.7-д ба БОАЖГ-ын даргын гүйцэтгэгч тус бүртэй байгуулсан **“Ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ”**¹⁰-ний тусгай нөхцлийн “ж”-д **“Ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилт хийх” гэж заасан байна.** Иймээс БОАЖГ нь гүйцэтгэгчээр 3 жилийн турш ойжуулсан талбайд нөхөн тарилтыг заавал шаардан хийлгүүлж тэнд мод ургуулсан байх ёстой. Энэ үүргээ аймгийн БОАЖГ хэрэгжүүлээгүй гэж үзэж тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
2. 2014-2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг гүйцэтгүүлэх хугацаанд тус газрын даргын албыг өөр хүн хашиж байсан тул аймгийн БОАЖГ-ын даргад сахилгын шийтгэл ногдуулах саналыг Төрийн аудитын хуульд заасны дагуу аймгийн Засаг даргад хүргүүлэх аудитын багийн шийдвэртэй санал нийлэхгүй байна гэсэн тайлбар ирүүлжээ. Бид өмнөх 2016 оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах тухай 01/90 ААГ-/2016/02-ГА дугаартай албан шаардлагыг аймгийн БОАЖГ-ын дарга Н.Баянмөнхөд 2016.10.12-ний өдөр хүргүүлсэн байна. Иймээс тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
3. 2017 онд Булган уул, Баянбулагт ойжуулсан 40 га талбайн нөхөн тарилтын ажлыг гүйцэтгүүлэхийг уламжилъя гэсэн нь аудитын тайлангийн дүгнэлттэй санал нийлж байна гэж үзлээ.

Дээр дурдсан үндэслэлээр аудитын тайланд ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

¹⁰ 2014-2018 онд гүйцэтгэгч тус бүртэй байгуулсан гэрээ

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/29

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1 дэх заалт, 2016 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2018 оны 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Ойжуулалтанд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 онд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн давтан аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр байршуулан аймгийн Засаг даргад болон аймгийн БОАЖГазарт хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нэргүйбаатар/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын 2018 оны 7/27 дугаар тушаалын
хавсралт №1

Албан шаардлага, Зөвлөмжийн жагсаалт

/Сая. Төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1	2	3	4	5	6	7
1	БОАЖГазар	16	134.3	2	-	14	
	ДҮН	16	134.3	2	-	14	

АЛБАН ШААРДЛАГА



Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Ойжуулалтанд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 оны зөвлөмжийн хэрэгжилт”-нд давтан аудит хийлээ. Аудитын явцад өмнөх аудитаар өгсөн 4 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

1. Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, ой бүхий сумын ойн менежмент төлөвлөгөөг хянаж, аймгийн засаг даргаар батлуулах, аймгийн “ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж нэн даруй батлуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу уг төлөвлөгөөг шинэчлэн батлуулаагүй.
2. “Ойжуулалтын ажлын гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, урьд оны ойжуулалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудтай улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулахгүй байх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 2014-2016 оны ойжуулалтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, 2 ба 3 дахь жилийн нөхөн тарилтыг хийж БОАЖГ-т хүлээлгэн өгөх гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй “Ойд хангай” ХХК, “Олз мод” ХХК-иудтай 2017, 2018 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалт хийлгэх гэрээ байгуулсан байна.
3. “Ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудаар тухайн жилийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэвэл зохих ойжуулалтыг заавал хийлгэж, хүлээн авах, өөрийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтыг хүлээн авсан гүйцэтгэлийн актыг олон нийтэд нээлттэй мэдээлэх” зөвлөмжийн хүрээнд 2017, 2018 онд ойн мэргэжлийн байгууллагууд нийт 52 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн гэх мэдээлэлтэй боловч албан ёсоор хүлээн авсан баримтгүй.

Төрийн Аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6 “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

хийх боломжгүй байлаа. Мөн хамгаалалтын хашаа бариагүй, анхааруулах самбар байршуулаагүй;

7. Хайрхан сумын Жарантай багийн Адуун зураад улсын төсвийн 13.8 сая төгрөгөөр “Олз мод” ХХК-ний 2015 онд ойжуулсан 20 га талбай нь байгалийн сэргэн ургалттай газар бөгөөд 2 хэсэг газарт 20х20 харьцаатай 2 жишиг талбай авч тарьцыг тоолж шалгахад тарьцын амьдралт 35 хувь, хамгаалалтын хашаа бариагүй;
8. Өндөр-улаан сумын Бэлхи багийн Гарчинд “Ойд хангай” ХХК-ний 2016 онд орон нутгийн төсвийн 12.8 сая төгрөгөөр 20 га-д гүйцэтгэсэн ойжуулалтын талбайд 5мх5м харьцаатай жишиг талбайг 4 хэсэг газар сонгон авч хэмжилт хийн ургацыг үзэхэд тарьц суулгац байхгүйгээс тоолох боломжгүй, хамгаалалтын хашаа бариагүй, анхааруулах самбар байршуулаагүй;
9. Эрдэнэбулган сумын Булган уулын баруун суганы 20 га-д “Олз мод” ХХК-ний 2017 онд 13.0 сая төгрөгөөр ойжуулсан гэх талбайд таримал мод байхгүй, хамгаалалтын хашаа бариагүй;
10. Батцэнгэл сумын Баян уул багийн овоотод 12.5 га-д “Ойд Хангай” ХХК-ний 2018 онд гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг 2 хэсэг газарт 20х20 хэмжээтэй жишиг талбай авч тарьцыг тоолоход тарьцын амьдралт 40.2 хувьтай, хамгаалалтын хашаа нь нурсан;
11. Чулуут сумын Зуун мод багийн Тооромтын үзүүр, Хэсэг мод хэмээх газарт 12.5 га-д Ойд хангай ХХК-ний 2018 онд ойжуулсан талбайд 5мх5м харьцаатай жишиг талбай авч тарьцыг тоолоход дундажаар 62.5 хувийн гүйцэтгэлтэй;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-д “өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж үйл ажиллагааныхаа талаар Төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах”, БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны А-96/71 хамтарсан тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4.7-д заасан **“Ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, шаардлагатай үед нөхөн тарилт хийнэ”**, БОАЖГ-ын даргын ойжуулалтын ажил гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний тусгай нөхцлийн нэмэлтийн “ж”-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.3 “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй ... зарцуулж төсвийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн”, 4.1.7 “Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгөөр 2015-2017 онд ойжуулалтын ажлыг гүйцэтгэхээр аймгийн БОАЖГ-ын даргатай гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагуудаар БОНХСайд, Сангийн Сайдын 2013 оны А-96/71 тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн аж

ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 4.7-д заасан **"Ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулах, ... нөхөн тарилтыг хийлгэх"**, мөн ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцлийн 32-д заасан "Чанарын баталгаат хугацаа 3 жил байна" гэсэн үүргийн биелэлтийг хангуулж шаардлага хангасан нөхөн тарилтыг хийлгүүлж, БОАЖГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг томилон дээрх ойжуулсан талбайг шалгаж хүлээн авах, нөхөн тарилтыг хийгээгүй болон гэрээний үүргийн биелэлтийг хангаагүй байгууллагуудыг гэрээний хэрэгжилтийг хангуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, асуудлыг шийдвэрлүүлэх

2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд гүйцэтгүүлсэн ойжуулалтын ажлын санхүүжилтийг тооцож олгох, гүйцэтгэлийг хүлээн авахдаа **"Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"**-ын 4.5, 4.6-д заасан зарчмыг мөрдөж, ойжуулалтын гүйцэтгэлийг мөн журмын 4.9-д заасны дагуу шалгаж хүлээн авч нотлох баримтуудыг Аудитын газарт ирүүлэх

Албан шаардлагын хэрэгжилтийг 2018 оны 12 сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн БОАЖГ-ын дарга Н.Баянмөнх, тус газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Баасансүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН²:
Ахлах аудитор
Д. Нэргүйбаатар

ЗӨВШӨӨРСӨН:
аймгийн БОАЖГ-ын
Дарга Н.Баянмөнх
Ойн асуудал хариуцсан
мэргэжилтэн Г.Баасансүрэн

² Төрийн Аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 01/132 АРА-2018/03-ГА-ДА

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу “Ойжуулалтанд төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн, 2016 оны зөвлөмжийн хэрэгжилт”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын явцад өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилт, 2017, 2018 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ойжуулалтын зарим ажлын бодит гүйцэтгэлийг Тэргүүлэх аудиторовн баталсан удирдамжийн дагуу шалгалтын ажлын хэсэг газар дээр нь үзэж, жишиг талбайд тарьцын ургалт, амьдралтыг тоолж шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Батцэнгэл сумын Баян Уул багийн Овгор улаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 13.3 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК-ний 2016 онд ойжуулалтын ажлыг гүйцэтгэсэн 15 га талбайд нөхөн тарилтыг хийгээгүй, тарьц суулгацын тоо хангалтгүй, байгалийн сэргэн ургалттай газарт ойжуулалт хийсэн, хашаа хамгаалалтгүй;
2. Өлзийт сумын Байшир багийн Шандатад орон нутгийн төсвийн 16.5 сая төгрөгөөр 2015 онд “Ойд хангай” ХХК-ний гүйцэтгэсэн 25 га талбайд ойжуулалтын нөхөн тарилт хийснийг нотлох боломжгүй, суулгасан тарьц байхгүй, хашаа хамгаалалтгүй, анхааруулах самбаргүй;
3. Хотонт сумын Өндөрт сант багийн Модот толгой 25 га-д улсын төсвийн 13.3 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК 2016 онд гүйцэтгэсэн ойжуулалтын жишиг талбайд тоологдсон тарьцын ургалт 50 хувьтай байв. Мөн хашаа хамгаалалтыг тор төмрөөр хийсэн боловч нутгийн иргэд торыг тасдаж ойжуулсан талбайд орсон, анхааруулах самбар байршуулаагүй;
4. Цэцэрлэг сумын Их булаг багийн Эхний хавтгай 40 га-д улсын төсвийн 27.8 сая төгрөгөөр “Ойд хангай” ХХК 2015 онд гүйцэтгэсэн ойжуулалтын жишиг талбай авч амьд тарьцыг тоолж үзэхэд 40 хувь амьдралттай, хамгаалах хашаа барьсан боловч нурж унасан, анхааруулах самбар байршуулаагүй;
5. Эрдэнэмандал сумын Тээл багийн Өлд орон нутгийн төсвийн 9.95 сая төгрөгөөр 2016 онд “Мөнхгэрэлмандал” ХХК-ний хийсэн БСУТА-ын 50 га талбайд хамгаалах хашаа бариагүй, анхааруулах самбаргүй, 2 хэсэг газарт жишиг талбай авч тоолоход үр цухуйгаагүй;
6. Хайрхан сумын Хэцүүгийн овоонд улсын төсвийн 13.8 сая төгрөгөөр “Олз мод” ХХК-ний 2015 онд ойжуулсан 20 га талбайд тарьц суулгац байхгүйгээс тооллого

1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй дээр дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч биелэлтийн тайланг гаргах

Албан шаардлагын хэрэгжилтийг холбогдох нотлох баримтуудын хамт 2018 оны 11 сарын 30-ний дотор ирүүлэхийг аймгийн БОАЖГ-ын дарга Н.Баянмөнх, мэргэжилтэн Г.Баасансүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

Г.ЦОГ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

АРХАНГАЙ АЙМГИЙН БОАЖГ-ЫН

ДАРГА.....Н.БАЯНМӨНХ

МЭРГЭЖИЛТЭН..... Г.БААСАНСҮРЭН

¹ Төрийн Аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.